



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 1.4 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 1.5 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Цахим гарын үсгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Бодлогын чиглэл батлах тухай” А/25 дугаар тушаал, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Бодлогын баримтлах чиглэл батлах тухай” А/71 дүгээр тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагчийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Баримтлах чиглэл батлах тухай” А/16 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт дагаж мөрдөж байгаа баримтлах чиглэл, дүрэм, журмыг судалж уг хуульд нийцүүлэн шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

САЙД



Н.УЧРАЛ

1523011931